



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН САНГИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН  
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2023/114/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Санхүү-нийцлийн аудитын газрын захирал,  
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [nananchimegts@audit.gov.mn](mailto:nananchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер: Д.Энхдалай  
Утас: 260512 Цахим хаяг: [enkhdalaid@audit.gov.mn](mailto:enkhdalaid@audit.gov.mn)  
Ахлах аудитор: А.Даваадорж  
Утас: 261628 Цахим хаяг: [davaadorja@audit.gov.mn](mailto:davaadorja@audit.gov.mn)  
Аудитор: Д.Эрдэнэчимэг  
Утас: 261628 Цахим хаяг: [Erdenechimegda@audit.gov.mn](mailto:Erdenechimegda@audit.gov.mn)

Улаанбаатар хот  
2023 он

## АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	13
3.5.1 Төсвийн төлөвлөлт .....	13
3.5.2 Төсвийн гүйцэтгэл .....	13
3.5.3 Нэмэлт төсөв .....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	14
4.1 Ерөнхий зүйл .....	14
4.2 Материаллаг байдал .....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	15
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
4.5.1 Завсрын аудитын талаар .....	17
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн .....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	18
5.1 Төлбөрийн акт .....	18
5.2 Албан шаардлага .....	18
5.3 Зөвлөмж .....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	21
6.1. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл .....	21
6.2. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл .....	22
6.3. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	24



**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ШУТСан	Шинжлэх ухаан, технологийн сан
ШУТҮЗ	Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөл



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2023.02.20 № 07/320  
танай -ны № -т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шинжлэх ухаан, технологийн сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шинжлэх ухаан, технологийн сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.


Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон 151,549.8 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8, 48 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйл, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Засгийн газрын 2021 оны 299 дүгээр тогтоолоор Шинжлэх ухаан, технологийн сангийн төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 11 хүрээлэнг Боловсрол, шинжлэх ухааны яамны шууд харьяанд шилжүүлж, төсвийн төвлөрүүлэн захирагчийн чиг үүрэг, статуст өөрчлөлт орж тус байгууллагыг төсвийн шууд захирагч байхаар шийдвэрлэсэн байна.

Шинжлэх ухаан, технологийн сан нь Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/22 дугаар тушаалаар нийт 372 төсөлд 6,792,966.2 мянган төгрөгийн санхүүжилт олгожээ. Үүнээс тайлант онд шинээр 199 төслийн гэрээ байгуулж, 2,253,998.9 мянган төгрөгөөр санхүүжүүлсэн байна.

Z:\Yawsan\_Bichigt\2023\0220 SNAG-16 Docx





Оюуны өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дахь хэсэгт заасны дагуу Шинжлэх ухаан, технологийн сангийн 37,350.0 мянган төгрөгийн санхүүжилтээр Оюуны өмчийн газар, Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институт хамтран, оюуны өмчийн үнэлгээ хийх гарын авлага боловсруулах ажлын хүрээнд сургалтын хөтөлбөрийг батлуулан, мэргэшсэн үнэлгээчин бэлтгэх сургалтыг зохион байгуулж, Монгол улсад анх удаа 17 хөрөнгийн үнэлгээчинд оюуны өмчийн үнэлгээ хийх эрх олгосон байна.

#### **Аудитын гол асуудал**

Засгийн газрын 2007 оны 146 дугаар тогтоолоор баталсан "Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөлийн дүрэм"-ийн 1.6-д "Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний багцад тусган санхүүжүүлнэ" гэж заасны дагуу Шинжлэх ухаан, технологийн сангаас зөвлөлийн үйл ажиллагаанд нийт 243,064.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах зорилтын хүрээнд Засгийн газрын 299 дүгээр тогтоол, ШУТҮЗ-ийн зөвлөмжийн дагуу аймаг, нийслэлд шинжлэх ухааны зөвлөл байгуулагдаж, "Аймаг, нийслэлийн Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн үлгэрчилсэн дүрэм"-ийн загварыг боловсруулан БШУЯ-д хүргүүлсэн байна.

Үндэсний зөвлөлийн хурлаас гарсан зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, Аймаг, нийслэлийн Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор Аймаг, нийслэлийн Боловсролын газарт Шинжлэх ухаан хариуцсан мэргэжилтэн ажиллуулж байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллагын тайлант онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөний чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгасан хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт 97.9 хувьтай байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

*B. M*

Ц.НАРАНЧИМЭГ





## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)</b>	<b>12,500,266,839.16</b>	<b>12,508,854,815.25</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>362,294,369.70</b>	<b>350,896,971.90</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	630,216.90
33103	ХАОАТ-ын авлага	-	630,216.90
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	359,680,000.00	337,680,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	2,614,369.70	10,381,255.00
33500	Бусад авлага	-	2,205,500.00
33510	Байгууллагаас авах авлага	-	2,205,500.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>12,060,708,824.96</b>	<b>12,084,667,100.55</b>
34600	Урьдчилж гарсан зардал	12,058,907,229.80	12,082,865,505.39
34700	Бусад урьдчилгаа	1,801,595.16	1,801,595.16
34710	Урьдчилгаа тооцоо	1,801,595.16	1,801,595.16
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	1,801,595.16	1,801,595.16
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>77,263,644.50</b>	<b>73,290,742.80</b>
35100	Түүхий эд материал	35,573,190.00	25,458,000.00
35110	Тусгай зориулалттай материал	35,573,190.00	25,458,000.00
35400	Хангамжийн материал	41,690,454.50	47,832,742.80
35410	Бичиг хэргийн материал	5,196,162.00	6,740,152.00
35420	Аж ахуйн материал	1,643,257.00	1,916,407.30
35440	Түлш, шатах тослох материал	3,550,812.00	7,258,200.00
35470	Бусад хангамжийн материал	31,300,223.50	31,917,983.50
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)</b>	<b>218,586,537.98</b>	<b>204,472,399.18</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>218,586,537.98</b>	<b>204,472,399.18</b>
39200	Биет хөрөнгө	201,705,936.34	198,995,524.14
39203	Авто-тээврийн хэрэгсэл	4,450,000.00	4,450,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл	(2,002,500.09)	(2,892,500.13)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	150,453,959.30	196,726,719.30
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(26,659,951.48)	(63,200,576.84)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	83,425,667.82	83,915,567.82
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(15,950,757.96)	(27,993,204.76)
39217	Номын фонд	7,989,518.75	7,989,518.75
39300	Биет бус хөрөнгө	16,880,601.64	5,476,875.04
39301	Программ хангамж	43,910,300.00	45,110,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл - Программ хангамж	(33,996,365.04)	(43,813,425.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	8,360,000.00	8,360,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл - Бусад биет бус хөрөнгө	(1,393,333.32)	(4,179,999.96)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)</b>	<b>12,718,853,377.14</b>	<b>12,713,327,214.43</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)</b>	<b>137,500.00</b>	<b>-</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>137,500.00</b>	<b>-</b>
41300	Өглөг	137,500.00	-
41360	Бусад өглөг	137,500.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	137,500.00	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)</b>	<b>12,718,715,877.14</b>	<b>12,713,327,214.43</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>12,718,715,877.14</b>	<b>12,713,327,214.43</b>
51101	-Төрийн	123,479,820.74	123,479,820.74
51200	Хуримтлагдсан үр дүн	12,595,236,056.40	12,589,847,393.69
51210	Өмнөх үеийн үр дүн	12,834,215,242.62	12,595,236,056.40
51220	Тайлант үеийн үр дүн	(238,979,186.22)	(5,388,662.71)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)</b>	<b>12,718,853,377.14</b>	<b>12,713,327,214.43</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>6,386,413,117.82</b>	<b>10,097,933,924.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>76,018,442.12</b>	<b>44,883,860.00</b>
1200	Нийтлэг татварын бус орлого	76,018,442.12	44,883,860.00



Шинжлэх ухаан, технологийн сангийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	65,800,462.12	44,883,860.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Материал	10,217,980.00	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>6,310,394,675.70</b>	<b>10,053,050,064.00</b>
1310	Улсын төсвөөс	6,268,433,692.00	10,011,207,682.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	6,268,433,692.00	10,011,207,682.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	37,880,682.70	41,842,382.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	37,880,682.70	41,842,382.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	4,080,301.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	4,080,301.00	-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>6,623,915,321.04</b>	<b>10,103,322,586.71</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>6,623,915,321.04</b>	<b>10,103,322,586.71</b>
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,192,979,372.60	10,056,692,287.79
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	319,534,906.29	439,697,362.92
210101	Үндсэн цалин	225,891,688.06	326,473,126.40
210102	Нэмэгдэл	65,142,218.23	70,558,756.52
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	28,501,000.00	30,766,000.00
210104	Урамшуулал		11,899,480.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,869,875.69	54,740,313.22
210201	Тэтгэврийн даатгал	29,565,038.33	37,760,900.95
210202	Тэтгэмжийн даатгал	3,291,126.23	4,442,456.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,525,380.99	3,517,004.99
210204	Ажилгүйдлийн даатгал	589,848.31	819,996.06
210205	Эрүүл мэндийн даатгал	5,898,481.83	8,199,955.15
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	96,229,800.00	133,724,500.00
210304	Байрны түрээс	96,229,800.00	133,724,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,217,582.46	75,688,793.68
210401	Бичиг хэрэг	6,605,745.00	28,698,632.00
210402	Тээвэр, шатахуун	2,945,797.00	21,086,312.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,195,422.46	10,389,223.08
210404	Ном, хэвлэл	520,400.00	166,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	155,700.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,794,518.00	15,348,426.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,388,210.00	204,000.00
210604	Урсгал засвар	1,388,210.00	204,000.00
2107	Томилолт, зочны зардал	600,000.00	3,808,000.00
210702	Дотоод албан томилолт	600,000.00	3,808,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,662,066,918.93	9,262,821,758.07
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,658,032,389.93	9,235,366,016.07
210803	Даатгалын үйлчилгээ	89,100.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	55,304.00	56,432.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,848,125.00	27,399,310.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	20,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,072,079.23	86,007,559.90
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,760,000.00	23,440,761.10
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	350,000.00	490,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	30,962,079.23	62,076,798.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	430,935,948.44	46,630,298.92
2132	Бусад урсгал шилжүүлэг	341,042,416.91	393,600.00
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	340,742,416.91	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	393,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	89,893,531.53	46,236,698.92
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	89,774,531.53	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	119,000.00	97,286.70
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг		46,139,412.22
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)</b>	<b>(237,502,203.22)</b>	<b>(5,388,662.71)</b>
<b>5</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>1,476,983.00</b>	<b>-</b>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	1,476,983.00	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	1,476,983.00	-
<b>6</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)</b>	<b>(238,979,186.22)</b>	<b>(5,388,662.71)</b>



### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>6,327,214,374.70</b>	<b>10,100,709,412.70</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>20,900,000.00</b>	<b>45,044,979.00</b>
1200	Нийтлэг татварын бус орлого	20,900,000.00	45,044,979.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	20,900,000.00	45,044,979.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	20,900,000.00	45,044,979.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>6,306,314,374.70</b>	<b>10,055,664,433.70</b>
1310	Улсын төсвөөс	6,268,433,692.00	10,011,207,682.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	6,268,433,692.00	10,011,207,682.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	37,880,682.70	44,456,751.70
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	37,880,682.70	44,456,751.70
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)</b>	<b>6,256,207,163.70</b>	<b>10,097,630,612.70</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>6,256,207,163.70</b>	<b>10,097,630,612.70</b>
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,822,956,845.56	10,040,619,058.78
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	319,069,158.06	337,112,171.85
210101	Үндсэн цалин	233,287,878.31	224,520,951.65
210102	Нэмэгдэл	61,465,708.23	69,967,743.20
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	24,315,571.52	30,723,997.00
210104	Урамшуулал		11,899,480.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,869,868.55	44,471,876.19
210201	Тэтгэврийн даатгал	29,598,637.11	30,587,923.67
210202	Тэтгэмжийн даатгал	3,282,726.28	3,839,913.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,518,660.92	2,678,407.58
210204	Ажилгүйдлийн даатгал	588,168.28	668,242.82
210205	Эрүүл мэндийн даатгал	5,881,675.96	6,697,388.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	85,471,200.00	133,724,500.00
210304	Байрны түрээс	85,471,200.00	133,724,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,913,633.52	25,214,670.85
210401	Бичиг хэрэг	4,149,400.00	4,715,100.00
210402	Тээвэр, шатахуун	3,306,200.00	7,338,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,048,126.52	8,060,580.85
210404	Ном, хэвлэл	2,551,900.00	166,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	155,700.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,702,307.00	4,934,590.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,482,000.00	574,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,000,000.00	
210604	Урсгал засвар	1,482,000.00	574,800.00
2107	Томилолт, зочны зардал	600,000.00	3,808,000.00
210702	Дотоод албан томилолт	600,000.00	3,808,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,342,200,985.43	9,495,223,039.89
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,326,166,456.43	9,482,528,097.89
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
210803	Даатгалын үйлчилгээ	89,100.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	55,304.00	56,432.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	15,848,125.00	12,638,510.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	20,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,350,000.00	490,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00	
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	350,000.00	490,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	433,250,318.14	57,011,553.92
2132	Бусад урсгал шилжүүлэг	340,742,416.91	393,600.00
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	340,742,416.91	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		393,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	92,507,901.23	56,617,953.92
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	89,774,531.53	
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,733,369.70	10,478,541.70
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг		46,139,412.22
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)</b>	<b>71,007,211.00</b>	<b>3,078,800.00</b>
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>		
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>71,007,211.00</b>	<b>3,078,800.00</b>



Шинжлэх ухаан, технологийн сангийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>71,007,211.00</b>	<b>3,078,800.00</b>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	71,007,211.00	3,078,800.00
2251	Үндсэн хөрөнгө олж бэлтгэхэд төлсөн	71,007,211.00	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	71,007,211.00	3,078,800.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)</b>	<b>(71,007,211.00)</b>	<b>(3,078,800.00)</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	123,479,820.74		12,834,215,242.62	12,957,695,063.36
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(238,979,186.22)	(238,979,186.22)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	123,479,820.74		12,595,236,056.40	12,718,715,877.14
4	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	123,479,820.74		12,595,236,056.40	12,718,715,877.14
5	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	123,479,820.74		12,595,236,056.40	12,718,715,877.14
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	123,479,820.74		12,595,236,056.40	12,718,715,877.14
7	Тайлант үеийн үр дүн			(5,388,662.71)	(5,388,662.71)
8	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	123,479,820.74		12,589,847,393.69	12,713,327,214.43

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
12	Татварын бус орлого	10,216,824,200.00	10,010,113,248.78	206,710,951.22	97.5
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/		45,044,979.00	(45,044,979.00)	
12200	Тусламжийн орлого	10,216,824,200.00	9,965,068,269.78	251,755,930.22	97.5
122005	Төсвөөс санхүүжих	10,216,824,200.00	9,965,068,269.78	251,755,930.22	97.5
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>10,216,824,200.00</b>	<b>10,010,113,248.78</b>	<b>206,710,951.22</b>	<b>97.9</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>10,216,824,200.00</b>	<b>10,010,113,248.78</b>	<b>206,710,951.22</b>	<b>97.9</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>10,216,430,600.00</b>	<b>10,009,719,648.78</b>	<b>206,710,951.22</b>	<b>97.9</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	337,112,200.00	337,112,171.85	28.15	100.0
210101	Үндсэн цалин	227,453,200.00	224,520,951.65	2,932,248.35	98.7
210102	Нэмэгдэл	70,783,000.00	69,967,743.20	815,256.80	98.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,176,000.00	30,723,997.00	(8,547,997.00)	138.5
210104	Урамшуулал	1,000,000.00	11,899,480.00	(10,899,480.00)	1,189.9
210105	Гэрээт ажлын хөлс	15,700,000.00		15,700,000.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,477,500.00	44,471,876.19	1,005,623.81	97.7
210201	Тэтгэврийн даатгал	31,938,400.00	30,587,923.67	1,350,476.33	95.7
210202	Тэтгэмжийн даатгал	4,095,800.00	3,839,913.38	255,886.62	93.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,518,200.00	2,678,407.58	(160,207.58)	106.3
210204	Ажилгүйдлийн даатгал	629,600.00	668,242.82	(38,642.82)	106.1
210205	Эрүүл мэндийн даатгал	6,295,500.00	6,697,388.74	(401,888.74)	106.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	133,724,500.00	133,724,500.00	-	100.0
210304	Байрны түрээс	133,724,500.00	133,724,500.00	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	13,708,500.00	13,708,460.85	39.15	100.0
210401	Бичиг хэрэг	1,253,400.00	1,215,100.00	38,300.00	96.9
210402	Тээвэр, шатахуун	1,735,800.00	500,000.00	1,235,800.00	28.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,092,100.00	7,066,370.85	1,025,729.15	87.2



Шинжлэх ухаан, технологийн сангийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210404	Ном, хэвлэл	535,000.00	166,200.00	368,800.00	31.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,092,200.00	4,770,790.00	(2,678,590.00)	228.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>574,800.00</b>	<b>574,800.00</b>	-	<b>100.0</b>
210604	Урсгал засвар	574,800.00	574,800.00	-	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>9,685,343,100.00</b>	<b>9,479,637,839.89</b>	<b>205,705,260.11</b>	<b>97.8</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,672,640,000.00	9,466,942,897.89	205,697,102.11	97.8
210804	Тээврийн хэрэгслийн татвар	56,400.00	56,432.00	(32.00)	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,646,700.00	12,638,510.00	8,190.00	99.9
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>490,000.00</b>	<b>490,000.00</b>	-	<b>100.0</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	490,000.00	490,000.00	-	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>393,600.00</b>	<b>393,600.00</b>	-	<b>100.0</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	393,600.00	393,600.00	-	100.0
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>24</b>	<b>24</b>	<b>0</b>	<b>100.0</b>
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>24</b>	<b>24</b>	<b>0</b>	<b>100.0</b>
620001	Удирдах ажилтан	1	1	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	22	22	0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	1	1	0	100.0

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (I)</b>	<b>44,456,751.70</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>44,456,751.70</b>
<b>210</b>	<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>33,978,210.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>11,506,210.00</b>
210401	Бичиг хэрэг	3,500,000.00
210402	Тээвэр, цатахуун	6,838,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,004,210.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	163,800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,808,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	3,808,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>18,664,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,664,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>10,478,541.70</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>10,478,541.70</b>
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	10,478,541.70
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР (II)</b>	<b>44,456,751.70</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>44,456,751.70</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>44,456,751.70</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	44,456,751.70



### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сан нь Шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлийн онолын суурь судалгаа хийх, засгийн газрын (Улсын) захиалгатай шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэхэд тэтгэлэг олгох, эрдэм шинжилгээний ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх, инновацын төсөл хэрэгжүүлэх, гарааны бизнест санхүүгийн дэмжлэг олгох, технологи, үйлдвэрлэлийн туршилт, зүгшрүүлэлтэд дэмжлэг үзүүлэх, шинжлэх ухаан, технологийн сангийн үйл ажиллагаа, үндсэн хөрөнгөтэй холбогдсон зардлыг санхүүжүүлэх, шинжлэх ухаан, инновацын үр дүнд бий болсон бүтээгдэхүүн үйлчилгээг олон улсад сурталчлах борлуулахад дэмжлэг үзүүлэх, эрдэм шинжилгээ судалгааны ажлын тайлан, эрдмийн зэрэг хамгаалсан диссертацийг фондод хадгалж, Монгол улсын Оюуны санг бүрдүүлэх, хамгаалах, сурталчлах эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг хийж байна.

Шинжлэх ухаан, технологийн сангийн үйл ажиллагааны зорилго нь шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлийн онолын суурь судалгаа гүйцэтгэх, шинжлэх ухаан, технологийн болон, инновацын төсөл, арга хэмжээг нэвтрүүлэх, эрдэм шинжилгээний ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Шинжлэх ухаан, технологийн сан эрхэм зорилгоо Шударга ёс, ил тод байдлыг эрхэмлэн, Олон улсын жишигт нийцсэн ахисан түвшний бүтээлч судалгааг тогтмол санхүүжүүлэх замаар Монгол улсын тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулна гэж тодорхойлсон байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;
- Инновацийн тухай хууль
- Оюуны өмчийн тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;

Шинжлэх ухаан, технологийн сангийн Захиргаа, хяналт мониторингийн газраас шинжлэх ухааны салбар, төслийн сэдэв агуулга, түлхүүр үгийн илэрцийг үндэслэн сонгосон 1086 мэргэжлийн шинжээч төслүүдийг "Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх журам"-д заасан шалгуур үзүүлэлтийг хангасан эсэх талаар бичгээр дүгнэлт гарган ажилласан байна.

Шинжлэх ухаан, технологийн болон инновацын төслийн сонгон шалгаруулалтад ирсэн нийт 497 төслийн материалыг "Шинжлэх ухаан, технологийн болон инновацын төслийн саналд үнэлгээ өгч, дүгнэлт гаргах аргачлал"-ын дагуу мэргэжлийн шинжээчдээр үнэлүүлж, дүгнэлт гаргасан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил хэрэгжүүлэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.



Шинжлэх ухаан, технологийн сангийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Боловсрол шинжлэх ухааны сайдын 2021 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн баталж мөрдөж байгаа нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Шинжлэх ухаан, технологийн сангийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн ба тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,526.2 мянган төгрөгөөр буюу 0.04 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	362,294.4	350,897.0	(11,397.4)
Урьдчилгаа	12,060,708.8	12,084,667.1	23,958.3
Бараа материал	77,263.6	73,290.7	(3,972.9)
Үндсэн хөрөнгө	218,586.6	204,472.4	(14,114.2)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>12,718,853.4</b>	<b>12,713,327.2</b>	<b>(5,526.2)</b>
Өр төлбөр	137.5	-	(137.5)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	12,718,715.8	12,713,327.2	(5,388.6)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>12,718,853.4</b>	<b>12,713,327.2</b>	<b>(5,526.2)</b>

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Авлагын дансны үлдэгдэл 350,897.0 мянган төгрөг болж 11,397.4 мянган төгрөгөөр буурсан байна. Авлага дансны үлдэгдэлд олон жилийн насжилттай Шинжлэх ухаан, технологийн сангаас 2002-2012 онд Зэхэц ажлын санхүүжилтэд эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон 18 зээлдэгчтэй холбогдох 337,680.0 мянган төгрөг байгаа нь нийт авлагын 96.2 хувийг эзэлж байна. Тайлант онд авлагыг 22,000.0 мянган төгрөгөөр бууруулсан, дээрх авлагыг барагдуулахаар "Өмгөөллийн дигест" ХХК-тай гэрээ байгуулсан боловч авлагыг барагдуулах гэрээний хэрэгжилт хангалтгүй байна.
- Урьдчилгаа дансны үлдэгдэлд ШУТСангаас 2015-2022 онд иргэн, ТББ, ХХК, их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудад олгосон 666 төслийн санхүүжилт 11,801,329.9 мянган төгрөг, 18 гэрээт ажлын санхүүжилтийн үлдэгдэл 281,535.6 мянган төгрөг байна.  
Төслийн хэрэгжүүлэх хугацаа дуусаж санхүүжүүлэгч, захиалагчид төслийн үр дүн, санхүүгийн тайланг хүлээлгэж өгөөгүй 29 төслийн 1,387,8780.4 мянган төгрөгийн урьдчилж гарсан зардлын үлдэгдэл байгаа нь хууль, журам хэрэгжихгүй байх, төсөл үр дүнгүй байх, төслийн зарцуулалтад тавих хяналт сул, санхүүгийн тайланд олон жилийн насжилттай зардал хуримтлагдах үр дагавартай байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 204,472.4 мянган төгрөг болж, 14,114.2 мянган төгрөгөөр буурсан нь шилжүүлэн авсан 44,883.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө болон тайлант хугацаанд байгуулсан 62,076.8 мянган төгрөгийн элэгдлийн зардлаас шалтгаалжээ.



- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 12,713,327.2 мянган төгрөг болж 5,388.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үйл ажиллагааны үр дүнгийн бууралттай холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 10,754,100.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 635,400.0 мянган төгрөгийн зардлыг төгрөгөөр бууруулж 10,118,800.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 98,024.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгон, төсөв захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 4 арга хэмжээнд 10,216,824.2 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 9,965,068.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлогоос 45,044.9 мянган төгрөгийг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 10,010,113.2 мянган төгрөг буюу 97.9 хувьтай байгаа нь бусдаар гүйцэтгүүлсэн бусад ажил үйлчилгээний нийтлэг төлбөр, хураамжийн зардлын төсвийг 205,705.2 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

БШУС-ын 2022 оны 8/1207 дугаар тушаалаар баталсан төсвийн төлөвлөгөөнд ШУТСангийн төслийн санхүүжилтийг 2022 оны 6 дугаар сард багтаан холбогдох хүрээлэн, төслийн удирдагчид бүрэн олгохоор төлөвлөсөн боловч БШУС-ын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 510, 517 дугаар тушаалаар зарцуулах эрх нээж, захиалгат болон хамтарсан 25 төслийн 885,058.0 мянга, гэрээт 19 ажлын 281,535.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Төсвийг хуваарийн дагуу олгоогүйгээс төсөл хэрэгжүүлэх ажил хугацаандаа хэрэгжихгүй, үр дүнгүй байх, санхүүжилтийн үлдэгдэл төрийн санд хураагдах эрсдэл үүссэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	570,061.2	523,938.6	46,122.6	91.9
2	Ажил олгогчоос олгох, тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	393.6	393.6	-	100.0
3	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	8,222,704.8	8,204,006.6	18,698.2	99.8
4	Инноваци өндөр технологи	1,423,664.6	1,281,774.4	141,890.2	90.0
	<b>Нийт дүн</b>	<b>10,216,824.2</b>	<b>10,010,113.2</b>	<b>206,711.0</b>	<b>97.9</b>

Хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөсөн төсвийн гүйцэтгэл 97.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн



бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрийг төсөл хэрэгжүүлэгч нараас төслийн арга зүйн түвшин, хэрэгжилтийн явц, хугацаа, үр дүн, үйлдвэрлэл үйлчилгээнд нэвтрүүлсэн байдал, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих хяналтын зардлын 1.0 хувийн орлогоос 44,456.7 мянган төгрөгийг бүрдүүлж, бараа, ажил үйлчилгээний зардалд 33,978.2 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 10,478.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, татаас санхүүжилтийн авлага үүсгэн бүртгэсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

#### **4. АУДИТЫН ТАЙЛАН**

##### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Шинжлэх ухаан, технологийн сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Шилэн дансны хуулийн хэрэгжилт, үндсэн хөрөнгө, төслийн санхүүжилтийн үр дүнтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүү-Нийцлийн аудитын газрын аудитор Д.Эрдэнэчимэг, ахлах аудитор А.Даваадорж нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Д.Энхдалай, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар хэрэгжүүлсэн.

Шинжлэх ухаан, технологийн сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 2/13 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

##### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг байгууллагын ирүүлсэн 2022 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 10,103,322.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 151,549.8 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

##### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Боловсрол, шинжлэх ухааны сайд, ТӨБЗГ-ын шийдвэрээр “Засгийн газрын автобааз” УТҮГ-т УНР-22-79 Ассент маркийн суудлын машиныг хүлээлгэн өгсөн байна.

Энэ хуулийн хүрээнд үндсэн үйл ажиллагааны зардлаас 206,711.0 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

##### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**



АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 29 дүгээр журмын дагуу, төсвийн хуваарь, хуваарийн өөрчлөлт, ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл зэрэг тухай бүр оруулах 88, сар бүр оруулах 44, хагас жил тутамд оруулах 4, улирал бүр оруулах 4, бүтэн жилээр оруулах 5, нийт 144 мэдээллийг холбогдох шийдвэрийн хамт хамт шилэн дансны цахим сайтад хугацаанд нь байршуулж ажилласан байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. БСШУ-ны сайдын 2018 оны А/349 дугаар тушаалаар Шинжлэх ухаан, технологийн төслийн саналд үнэлгээ өгч, дүгнэлт гаргах мэргэжлийн шинжээчдийг баталсан. Сонгосон мэргэжлийн шинжээчдийн нэрсийн жагсаалтыг 2018-2022 онуудад шинэчлээгүй, цахим сан бүрдүүлээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2014 оны 301 дүгээр тогтоолоор баталсан "Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх журам"-ын 4.4-т "Энэ журмын 1.3.1-д заасан төслийн саналд Шинжлэх ухааны академийн холбогдох Бага чуулган, 1.3.3, 1.3.4, 1.3.6-д заасан төслийн саналд Шинжлэх ухаан, технологийн сан, шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай хамтран, 1.3.2, 1.3.5-д заасан төслийн саналд шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага мэргэжлийн шинжээчийг сонгон ажиллуулж, дүгнэлт гаргах ажлыг тус тус зохион байгуулна..." гэж заасантай нийцэхгүй байна.

#### Шийдвэрлэсэн нь:

БСШУ-ны сайдын 2018 оны "Шинжлэх ухаан, технологийн төслийн саналд үнэлгээ өгч, дүгнэлт гаргах мэргэжлийн шинжээчдийг батлах тухай" А/349 дугаар тушаалыг шинэчлэх, мэргэжлийн шинжээчдийн цахим сан бүрдүүлж, төслийн саналд үнэлгээ өгч, дүгнэлт гаргах ажлыг цахимаар зохион байгуулах боломжийг бүрдүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

2. Засгийн газрын 2018 оны 289 дүгээр тогтоолоор ШУТҮЗ-ийн дарга нь Боловсрол шинжлэх ухааны сайд байхаар баталсан байна. ШУТҮЗ нь хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлогын төсөл боловсруулах, бодлогын хэрэгжилтэд үнэлэлт өгөх, шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах зөвлөмж гаргахаар заасан ба энэ чиг үүргийнхээ хүрээнд БШУС-д зөвлөмж өгч байгаа нь тухайн яаманд өгсөн зөвлөмж хэрэгжихгүй, хяналт сулрах эрсдэлтэй байна.

Энэ нь Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1. "Засгийн газар нь шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлогын талаар санал боловсруулах, бодлогын хэрэгжилтэд үнэлэлт өгөх, шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах талаар зөвлөмж гаргах үүрэг бүхий орон



тооны бус Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх/-тэй байна" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

ШУТҮЗ-ийн дарга нь БШУС байхаар баталсан шийдвэрийг хуульд нийцүүлэн өөрчлөх асуудлыг шийдвэрлүүлэх зөвлөмж хүргүүлэв.

3. БШУС-ын тушаалаар ШУТҮЗ-ийн өдөр тутмын үйл ажиллагаа, хуулиар тогтоосон чиг үүргийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах шинжээчийг хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллуулахдаа сарын цалинг ТҮШҮ-гийн цалингийн шатлалд дүйцүүлэн олгохыг ШУТҮЗ-ийн нарийн бичгийн даргад даалгасан боловч шинжээчдийн албан тушаалын тодорхойлолтыг Төрийн захиргааны албан тушаалаар батлан, хөдөлмөрийн гэрээ байгуулж, цалин олгосон байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Төрийн захиргааны албан тушаалд төрийн бодлого боловсруулахад мэргэшлийн зөвлөгөө өгөх, уг бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг төрийн захиргааны удирдлагаар хангах, зохион байгуулах чиг үүрэг бүхий дараахь албан тушаал хамаарна: 12.1.5. яамны Төрийн нарийн бичгийн дарга, яамны удирдах, гүйцэтгэх албан тушаал" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Цалингийн сүлжээг холбогдох хуульд нийцүүлэн өөрчлөх албан шаардлага хүргүүлэв.

4. ШУТСангийн мэдээллийн санд шинэ бүтээлийн 4,600 патент, ашигтай загварын 2,792 гэрчилгээ, 2711 бүтээгдэхүүний загварт эрхийн хамгаалалт хийгдсэн боловч эдгээрийг аж үйлдвэрт нэвтрүүлэх, үйлчилгээ болгож, орлого болгон хувиргах үйл ажиллагаа, үйлчилгээ, дэд бүтэц хангалтгүй байна.

Тухайлбал: ШУТСангийн санхүүжилтээр суурь болон технологи нэвтрүүлэх төслийн үр дүнгээр бүтээсэн малын шүлхий өвчний 913QL, 914QL, 915QL, 916QL, 917QL гэрчилгээтэй вакциныг 2022 онд үйлдвэрлэлийн түвшинд нэвтрүүлэхээр Мал эмнэлгийн хүрээлэн, Биокомбинат ТӨХК хооронд "Технологи дамжуулах лицензийн гэрээ" байгуулсан боловч гэрээ нь дугааргүй, хэрэгжүүлэх хугацааг тусгаагүй, үйлдвэрлэх ажил удаашралтай, салбар хоорондын уялдаагүй байна. Вакциныг 2019-2021 онд 100.0 хувь гадаадаас бэлтгэж, шүлхий өвчнийг бууруулах, урьдчилан сэргийлэх тусгай арга хэмжээнд 21,500.0 мянган толгой малыг хамруулж, улсын төсвөөс 43,408,600.0 мянган төгрөгийг зарцуулсан нь энэ хэмжээгээр импортыг бууруулах боломжийг алдсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", Оюуны өмчийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.2-д "оюуны өмчийн эдийн засгийн эргэлтийг дэмжих бодлого боловсруулж, салбар хоорондын уялдааг хангах", 19.1.-д "Оюуны өмчийн эрхийг лиценз, франчайз, мерчандайзийн болон бусад гэрээ, хэлцлээр бусдад бүрэн болон хэсэгчлэн ашиглуулах, өмчлөх эрх шилжүүлэх, оюуны өмчөөр хуулийн этгээдэд хөрөнгө оруулах, барьцаалах болон бусад хэлбэрээр эдийн засгийн эргэлтэд оруулж болно" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

ШУТСангийн мэдээллийн санд бүртгэлтэй, эрхийн хамгаалалт хийгдсэн патент, ашигтай загварын, бүтээгдэхүүнийг аж үйлдвэрт нэвтрүүлэх, үйлчилгээ болгож, орлого болгон хувиргах үйл ажиллагаа, үйлчилгээ, дэд бүтцийг сайжруулах ажлыг зохион байгуулах, Мал эмнэлгийн хүрээлэн, Биокомбинат ТӨХК хооронд "Технологи дамжуулах лицензийн гэрээ" - ний дагуу шүлхийн вакциныг үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажлыг 2023 онд багтаан хамтран ажиллаж, хэрэгжүүлэх зөвлөмж хүргүүлэв.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

ШУТСангийн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар эхний хагас жилийн баталгаажсан санхүүгийн тайланд аудит хийж, байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж аван эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратеги боловсруулсан.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар өгсөн 1 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 1 зөвлөмжийн биелэлтийг тулган баталгаажуулахад 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	500.0	1	500.0	100.0
Албан шаардлага	1	-	1	-	100.0
Зөвлөмж	1	-	1	-	100.0
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>500.0</b>	<b>3</b>	<b>500.0</b>	<b>100.0</b>



## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 91,951.2 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын тайланд орлого, зарлагыг 46,139.4 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан;
- Дээд шатны байгууллагаас шилжүүлж авсан 44,883.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хандив тусламжийн орлогоор зөрүүтэй бүртгэсэн;
- Нэмэлт санхүүжилтийн тайланд нэр данс зөрүүтэй гүйлгээг 928.0 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн.

Аудитаар нийт 1,876,397.7 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 3,101.6 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 1,870,460.4 мянган төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага хүргүүлж, 2,835.7 мянган төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн зөрчил 1,876,397.7 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдал түвшин 151,549.8 мянган төгрөгөөс их тул **Хязгаарлалттай** дүгнэлт өгөв.

### 5.1 Төлбөрийн акт

1. ШУТСангаас ШУТҮЗ-ийн үйл ажиллагаанд хамааралгүй аж ахуйн материал, хүнс худалдан авсан, анхан шатны баримтын бүрдэлгүй, зориулалт бус 1,300.0 мянган төгрөгийн зардал гаргасан нь *Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 "Тусгай сангийн хөрөнгийг батлагдсан төсвөөс хэтрүүлэх, хуульд зааснаас өөр зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно"* Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтуудыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан зөрчилд улсын төсөвт буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Өмнөх онд Петровис компанид шилжүүлсэн урьдчилгаа дансанд бүртгэлтэй, 1,801.6 мянган төгрөгийн шатахууныг хүлээн авч, орлогод бүртгээгүй нь *Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"* Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан зөрчилд улсын төсөвт буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

1. ШУТСангаас олгосон санхүүжилтээр 2015-2019 онуудад хэрэгжүүлсэн 6, ТЕЗ-ийн захиалгат 1,387,780.4 мянган төгрөгийн 29 төслийг хүлээж аваагүй, холбогдох арга хэмжээ авч ажиллаагүй нь Шинжлэх ухаан технологийн сангаас олгосон санхүүжилт үр ашиггүй зарцуулагдсан байх эрсдэлийг бий болгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 "*батлагдсан төсөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*", Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.5 "*төслийн гүйцэтгэл гэрээнд заасан шаардлага хангаагүй бол олгосон хөрөнгийг нөхөн төлүүлэх арга хэмжээ авах*", 17 дугаар зүйлийн 17.1.6 "*захиалсан эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын гүйцэтгэлд хяналт*

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.



тавьж, илэрсэн зөрчлийг арилгах асуудлыг гүйцэтгэгчтэй хамтран шийдвэрлэх" гэж заасныг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Яамдын эрдэм шинжилгээний салбар зөвлөлтэй хамтран хугацаа дууссан төслийн үр дүнгийн тайланг хэлэлцэн, хангалтгүй хэрэгжсэн төслийн санхүүжилтийг гэрээнд заасны дагуу буцаан төлүүлэх арга хэмжээг авч ажиллах.

2. Өмгөөллийн дигест ХХК-тай 2022 онд ШУТСангаас 2012-2019 онуудад "Зэхэц хөтөлбөр"-ийн хүрээнд эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон 18 зээлдэгчтэй холбогдох 337,680.0 мянган төгрөгийн зээлийн авлагыг барагдуулах гэрээ байгуулан ажилласан боловч авлага барагдаагүй, гэрээний хэрэгжилт хангалтгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 41 дүгээр зүйлийн 41.2-д "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ", 41.2.7 "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах" Иргэний хуулийн 350 дугаар зүйлийн 350.1.1 "гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэх" гэж заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Хууль хяналтын байгууллагатай хамтран ажиллаж олон жилийн насжилттай авлагыг бүрэн барагдуулах албан шаардлага өгөв.

3. "Салбарын эрдэм шинжилгээний байгууллагуудын шинжлэх ухаан, технологийн төслийн гүйцэтгэлд мониторинг хийх, асуудал шийдлийг тодорхойлох, үнэлэлт, дүгнэлт гаргах судалгааны ажил"-ын гүйцэтгэгчээр "Эжайл төслийн удирдлагын төв" ТББ-ыг 70,000.0 мянган төгрөгөөр гүйцэтгүүлэхээр шалгаруулж, нотлох баримт дутуу ажлын тайлан хүлээн авч санхүүжилт олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтуудыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төслийн үр дүнг тооцон, холбогдох арга хэмжээ авч ажиллах албан шаардлага хүргүүлэв.

4. Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн төсөл боловсруулах ажлыг 1.5 сарын хугацаанд 75,000.0 мянган төгрөгөөр гүйцэтгүүлж, нотлох баримт дутуу ажлын тайлан хүлээн авч санхүүжилт олгосон, цахим хуудсанд тендерийн урилгыг зарлан мэдээлээгүй, нээлттэй тендер шалгаруулахаас зайлсхийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 "энэ хуулийн 52.1.12-т дурдсан цахим хуудсанд тендерийн урилгыг зарлан мэдээлэх бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн доод хязгаар", мөн хуулийн 8.5 "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтуудыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төслийн үр дүнд дотоод хяналт хийж, холбогдох арга хэмжээ авч ажиллах албан шаардлага хүргүүлэв.



### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Балансын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Татварын хэлтэст ХХОАТ-ыг илүү төлж 630.2 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Авлага ба төлбөрийн тооцоог хянаж байх зөвлөмж өгөв.

#### 2. Балансын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Адмон принт ХХК-тай эрдэмтэн судлаачдын төслийн үр дүнд бий болсон бүтээгдэхүүнийг гадаад хэл дээр хэвлүүлэх 2,505.5 мянган төгрөгийн тооцоог тайланд хугацаанд хийж тооцоо нийлж, үлдэгдлийг барагдуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Авлага ба төлбөрийн тооцоог хянаж байх зөвлөмж өгөв.

#### 3. Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: БШУС-ын 2022 оны 8/1207 дугаар тушаалаар баталсан төсвийн төлөвлөгөөнд ШУТСангийн төслийн санхүүжилтийг 2022 оны 6 дугаар сард багтаан холбогдох хүрээлэн, төслийн удирдагчид бүрэн олгохоор төлөвлөсөн боловч 2022 оны 12 дугаар сард БШУС-ын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 510, 517 дугаар тушаалаар зарцуулах эрх нээж 25 захиалгат болон хамтарсан төсөлд 885,058.0 мянган төгрөгийн, 19 гэрээт ажилд 281,535.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.5 "Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн батлагдсан төсвийг төсвийн төвлөрүүлэн захирагч бүрээр, төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагдахгүй төсвийг төсвийн шууд захирагч бүрээр, энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар, хүрэх үр дүнгийн хамт батлах", 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй, байхаар төлөвлөж, зарцуулах" заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийг хуваарийн дагуу олгох, төсөл хэрэгжүүлэх ажлын үр дүнг сайжруулах зөвлөмж өгөв. Байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье



Шинжлэх ухаан, технологийн сангийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**  
**6.1. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж			
										Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын тайлангийн орлого, зарлагыг төвлөрүүлэх шилжүүлгийн дүнгээр залруулсан	1	46,139.4		46,139.4	1			1	46,139.4					
2	Дээд шатны байгууллагаас шилжүүлж авсан үндсэн хөрөнгийг хандив тусламжийн орлогоор бүртгэснийг залруулсан.	1	44,883.8			1	44,883.8		1	44,883.8					
3	Нэр данс зөрүүтэй гүйлгээг нэмэлт санхүүжилтийн тайланд залруулсан	1	928.0			1	928.0		1	928.0					
	Дүн	3	91,951.2		46,139.4	5	45,811.8		5	91,951.2					





Шинжлэх ухаан, технологийн сангийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6.2. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Д.д	Зөрчлийн товч утга	Үүнээс /мянган төгрөгөөр/											
		Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	ШУТСангаас олгосон санхүүжилтээр 2016-2019 онуудад хэрэгжүүлсэн 6 ТЕЗ-ийн захиалгат 1,387,780.4 мянган төгрөгийн 29 төслийг одрог хүртэл хүлээн аваагүй, холбогдох арга хэмжээ авч ажиллаагүй нь ШУТСангаас олгосон санхүүжилт үр ашиггүй байх эрсдэлтэй байна.	1	1,387,780.4			1	1,387,780.4						
2	Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн төсөл боловсруулах ажлыг 1.5 сарын хугацаанд 75,000.0 мянган төгрөгөөр гүйцэтгүүлэхээр шалгаруулж, нотлох баримт дутуу ажлын тайлан хүлээн авч санхүүжилт олгосон, цахим хуудсанд тендерийн урилгыг зарлан мэдээлээгүй, нээлттэй тендер шалгаруулахаас зайлсхийсэн байна.	1	75,000.0			1	75,000.0						
3	"Салбарын эрдэм шинжилгээний байгууллагуудын шинжлэх ухаан, технологийн төслийн гүйцэтгэлд мониторинг хийх, асуудал шийдлийг тодорхойлох, үнэлэлт, дүгнэлт гаргах судалгааны ажил"-ын гүйцэтгэлээр "Эжйил төслийн удирдлагын төв" ТББ-ыг 70,000.0 мянган төгрөгөөр гүйцэтгүүлэхээр шалгаруулж, нотлох баримт дутуу ажлын тайлан хүлээн авч санхүүжилт олгосон байна.	1	70,000.0			1	70,000.0						



Шинжлэх ухаан, технологийн сангийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

4	"ШУТСаंगाас ШУТҮЗ-ийн үйл ажиллагаанд хамааралгүй аж ахуйн материал, хүнс худалдан авсан, анхан шатны баримтын бүрдэлгүй, зориулалт бус 1,300.0 мянган төгрөгийн зардал гаргасан байна.	1	1,300.0	1	1,300.0										
5	Өмнөх онд Петровис компанид шилжүүлсэн шатахууны урьдчилгаа 1,801.6 мянган төгрөгийн тооцоог хийгээгүй, шатахууныг хүлээн авч орлогод бүртгээгүй байна.	1	1,801.6	1	1,801.6										
6	ШУТСаंगाас 2012-2019 онуудад Зэхэц хөтөлбөрийн хүрээнд эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон 18 зээлдэгчтэй холбогдох 337,680.0 мянган төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй, авлагыг барагдуулахаар 2022 онд "Өмгөөллийн дигест" ХХК-тай гэрээ байгуулсан боловч авлагыг барагдуулаагүй, гэрээний хэрэгжилт хангалтгүй байна.	1	337,680.0	1	337,680.0					337,680.0					
7	Татварын хэлтэст ХХОАТ-ыг илүү төлж авлага үүсгэсэн байна.	1	630.2		630.2				1		630.2				
8	Адмон принт ХХК-тай эрдэмтэн судлаачдын төслийн үр дүнд бий болсон бүтээгдэхүүнийг гадаад хэл дээр хэвлүүлэх тооцоог тайланд хугацаанд хийж тооцоо нийлж, үлдэгдлийг барагдуулаагүй байна.	1	2,505.5		2,505.5				1		2,505.5				
9	БСШУЯ-ны 2022 оны 8/1207 дугаар тушаалаар баталсан төсвийн төлөвлөгөөнд ШУТСангийн төслийн санхүүжилтийг 2022 оны 6 дугаар сард багтаан холбогдох хүрээлэн, төслийн удирдагчид бүрэн олгохоор төлөвлөсөн боловч 2022 оны 12 дугаар сард БШУС-ын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 510, 517 дугаар тушаалаар зарцуулах эрх нээж 25 захиалгат болон хамтарсан төсөлд 885,058.0 мянган төгрөгийн, 19 гэрээт ажилд 281,535.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.	1							1						
	Дүн	9	1,876,397.7	2	3,101.6	4	1,870,460.4	3		2,835.7					

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ХЯЗГААРЛАЛТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ



Шинжлэх ухаан, технологийн сангийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6.3. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Үүнээс		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Албан шаардлага		Тоо	Дүн
						Тоо	Дүн		
	<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
1	БСШУ-ны сайдын 2018 оны А/349 дугаар тушаалаар Шинжлэх ухаан, технологийн төслийн саналд үнэлгээ өгч, дүгнэлт гаргах мэргэжлийн шинжээчдийг баталсан. 2018-2022 онуудад сонгосон мэргэжлийн шинжээчдийн нэрсийн жагсаалтыг шинэчлээгүй, цахим сан бүрдүүлээгүй байна.	1				1			
2	Засгийн газрын 2018 оны 289 дүгээр тогтоолоор ШУТҮЗ-ийн дарга нь Боловсрол шинжлэх ухааны сайд байхаар баталсан байна. ШУТҮЗ нь хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлогын төсөл боловсруулах, бодлогын хэрэгжилтэд үнэлэлт өгөх, шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах зөвлөмж гаргахаар заасан ба энэ чиг үүргийнхээ хүрээнд БСШУ-ны сайдад зөвлөмж өгч байгаа нь тухайн яаманд өгсөн зөвлөмж хэрэгжихгүй, хяналт сулрах эрсдэлтэй байна.	1					1		
3	БШУС-ын тушаалаар ШУТҮЗ-ийн өдөр тутмын үйл ажиллагаа, хуулиар тогтоосон чиг үүргийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах шинжээчийг хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллуулахдаа сарын цалинг ТҮШҮ-гийн цалингийн шатлалд дүйцүүлэн олгохыг ШУТҮЗ-ийн нарийн бичгийн даргад даалгасан боловч шинжээчдийн албан тушаалын тодорхойлолтыг Төрийн захиргааны албан тушаалаар батлан, хөдөлмөрийн гэрээ байгуулж, цалин олгосон байна.	1				1			-
4	ШУТСангийн мэдээллийн санд шинэ бүтээлийн 4,600 патент, ашигтай загварын 2,792 гэрчилгээ, 2711 бүтээгдэхүүний загварт эрхийн хамгаалалт хийгдсэн боловч эдгээрийг аж үйлдвэрт нэвтрүүлэх, үйлчилгээ болгож, орлого болгон хувиргах үйл ажиллагаа, үйлчилгээ, дэд бүтэц хангалтгүй байна. Тухайлбал: ШУТСангийн санхүүжилтээр суурь болон технологи нэвтрүүлэх төслийн үр дүнгээр бүтээсэн малын шүлхий өвчний 913QL, 914QL, 915QL, 916QL, 917QL гэрчилгээтэй вакциныг 2022 онд үйлдвэрлэлийн түвшинд нэвтрүүлэхээр Мал эмнэлгийн хүрээлэн, Биокорбинат ТӨХК хооронд "Технологи дамжуулах лицензийн гэрээ" байгуулсан боловч гэрээ нь дугааргүй, хэрэгжүүлэх хугацааг тусгааргүй, үйлдвэрлэх ажил удаашралтай, салбар хоорондын уялдаа хангалтгүй байна. 2019-2021 онд вакциныг 100.0 хувь гадаадаас бэлтгэж, шүлхий өвчнийг бууруулах, урьдчилан сэргийлэх тусгай арга хэмжээнд 21,500.0 мянган толгой малыг хамруулж, улсын төсвөөс 43,408,600.0 мянган төгрөгийг зарцуулсан нь энэ хэмжээгээр импортыг бууруулах боломжийг алдсан байна.	1						1	
	Нийт дүн	4				2			2





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2023 оны 02 дугаар сарын 24 № 09/А0140460

Улаанбаатар хот

СНАГ-2023/114/НА-СТА-ТМЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Шинжлэх ухаан, технологийн сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шинжлэх ухаан, технологийн сангаас Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн үйл ажиллагаанд хамааралгүй аж ахуйн материал, хүнс худалдан авсан, анхан шатны баримтын бүрдэлгүй, зориулалт бус 1,300,000.00 төгрөгийн зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 "Тусгай сангийн хөрөнгийг батлагдсан төсвөөс хэтрүүлэх, хуульд зааснаас өөр зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

- Зориулалт бусаар зарцуулсан 1,300,000.00 /Нэг сая гурван зуун мянган/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
- Актын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Шинжлэх ухаан, технологийн сангийн захирал Д.Одгэрэл, ахлах нягтлан бодогч Б.Отгонжаргал нарт даалгав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ӨГСӨН:**

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АУДИТОР

*(Handwritten signatures)*

Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ  
Д.ЭРДЭНЭЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-26230

Z:\AKT\2023\02\24\SNAГ-7.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ХАЯГААР ГАЛТТАЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2023 оны 02 дугаар сарын 24 № 10/А0170460

Улаанбаатар хот

СНАГ-2023/114/НА-СТА-ТМЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Шинжлэх ухаан, технологийн сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх онд Петровис компанид шилжүүлсэн шатахууны урьдчилгаа тооцоо хийгээгүй, 1,801,600.00 төгрөгийн шатахууныг хүлээн авч орлогод бүртгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

- Петровис компанид шилжүүлсэн шатахууны урьдчилгаа тооцоог хийж, бүртгээгүй 1,801,600.00 /Нэг сая найман зуун нэгэн мянга зургаан зуун/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
- Актын биелэлтийг 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор
- аудитын газарт ирүүлэхийг Шинжлэх ухаан, технологийн сангийн захирал Д.Одгэрэл, ахлах нягтлан бодогч Б.Отгонжаргал нарт даалгав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ӨГСӨН:**

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ  
Д.ЭРДЭНЭЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-26 230

Z:\Akti\2023\0224\SNAG-7.Docx

0001099522





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 дугаар сарын 04 № 66/НОТГОНОГО  
СНАГ - 2023/114/НА-СТБ - НУБ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Шинжлэх ухаан, технологийн сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шинжлэх ухаан, технологийн сангаас 2012-2019 онуудад Зэхэц хөтөлбөрийн хүрээнд эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон 18 зээлдэгчтэй холбогдох 337,680,000.00 төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй, авлагыг барагдуулахаар 2022 онд Өмгөөллийн дигест ХХК-тай гэрээ байгуулсан боловч авлагыг барагдуулаагүй, гэрээний хэрэгжилт хангалтгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 41 дүгээр зүйлийн 41.2 "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ", 41.2.7 "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", Иргэний хуулийн 350 дугаар зүйлийн 350.1.1 "гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль хяналтын байгууллагатай хамтран ажиллаж, олон жилийн насжилттай авлагыг бүрэн барагдуулах, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шинжлэх ухаан технологийн сангийн захирал Д.Одгэрэл, ахлах нягтлан бодогч Б.Отгонжаргал нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**  
САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АУДИТОР

*(Handwritten signatures and stamps)*

Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ  
Д.ЭРДЭНЭЧИМЭГ

00018377

**01** **ХЯЗГААРЛАЛТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ**





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 дүгээр сарын 21 № 69/1907/0460  
СМАГ-2023/111/111-СМН-715

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Шинжлэх ухаан, технологийн сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Салбарын эрдэм шинжилгээний байгууллагуудын шинжлэх ухаан, технологийн төслийн гүйцэтгэлд мониторинг хийх, асуудал шийдлийг тодорхойлох, үнэлэлт, дүгнэлт гаргах судалгааны ажил"-ын гүйцэтгэгчээр Эжайл төслийн удирдлагын төв ТББ-ыг 70,000,000.00 төгрөгөөр гүйцэтгүүлэхээр шалгаруулж, нотлох баримт дутуу ажлын тайлан хүлээн авч, санхүүжилт олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төслийн үр дүнг шалгаж, холбогдох арга хэмжээг авч, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шинжлэх ухаан, технологийн сангийн захирал Д.Одгэрэл, ахлах нягтлан бодогч Б.Отгонжаргал нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ  
Д.ЭРДЭНЭЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засагийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-26-2330

Z:\Alban Shaardlaga\2023\0224\SMAG-7.Docx

0001082149





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 дугаар сарын 24 № 65/АУ/2023  
СНАГ-2023-1941/10-СЭВ-5485

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Шинжлэх ухаан, технологийн сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шинжлэх ухаан, технологийн сангаас олгосон санхүүжилтээр 2015-2019 онуудад хэрэгжүүлсэн 6 ТЭЗ-ийн захиалгат 1,387,780,400.00 төгрөгийн 29 төслийг одоог хүртэл хүлээгдэж аваагүй, холбогдох арга хэмжээ авч ажиллаагүй нь Шинжлэх ухаан, технологийн сангаас олгосон санхүүжилт үр ашиггүй байх эрсдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн өрөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.5 "төслийн гүйцэтгэл гэрээнд заасан шаардлага хангаагүй бол олгосон хөрөнгийг нөхөн төлүүлэх арга хэмжээ авах", 17 дугаар зүйлийн 17.1.6 "захиалсан эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгах асуудлыг гүйцэтгэгчтэй хамтран шийдвэрлэх" гэж заасныг тус тус зөрчсөн, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудитормын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Яамдын эрдэм шинжилгээний салбар зөвлөлтэй хамтран хугацаа дууссан төслийн үр дүнгийн тайланг хэлэлцэн хангалтгүй хэрэгжсэн төслийн санхүүжилтийг гэрээнд заасны дагуу буцаан төлүүлэх арга хэмжээг авч ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шинжлэх ухаан, технологийн сангийн захирал Д.Одгэрэл, ахлах нягтлан бодогч Б.Отгонжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ  
Д.ЭРДЭНЭЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264300

Z:\Alban Shaardlaga\2023\0224\SNAG-7.Docx







ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 дугаар сарын 24

№ 330/А0170460

Улаанбаатар хот

СМАГ-2023/114/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Шинжлэх ухаан, технологийн сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн төсөл боловсруулах ажлыг 1.5 сарын хугацаанд 75,000,000.00 төгрөгөөр гүйцэтгүүлж, нотлох баримт дутуу ажлын тайлан хүлээн авч санхүүжилт олгосон, цахим хуудсанд тендерийн урилгыг зарлан мэдээлээгүй, нээлттэй тендер шалгаруулахаас зайлсхийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5-д "энэ хуулийн 52.1.12-т дурдсан цахим хуудсанд тендерийн урилгыг зарлан мэдээлэх бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн доод хязгаар", мөн хуулийн 8.5-д "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Төслийн үр дүнд дотоод хяналт хийж, холбогдох арга хэмжээг авч, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Шинжлэх ухаан, технологийн сангийн захирал Д.Одгэрэл, ахлах нягтлан бодогч Б.Отгонжаргал нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ЭНХДАЛАЙ

АУДИТОР

Д.ЭРДЭНЭЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

Z:\Aiban Shaardlaga\2023\0224 SINAG-7.Docx



Утас: +976 51 261585  
Факс: +976 11 323266, 324653

Цахим шуудан: [info@audit.gov.mn](mailto:info@audit.gov.mn)  
Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Хаяг: Засгийн газрын IV байр  
Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг  
Улаанбаатар-15160, Монгол Улс